



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021-03-19 № 09

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгахаар тусгагдсаны дагуу Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын төслийн барилгын ажил санхүүжилтийн асуудлаас шалтгаалан зогссон байсныг нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэн 2021 оны улсын төсөвт тусгуулсан.

УИХ-ын гишүүн миний бие энэ асуудалд санаа тавьж, асуудал хариуцсан яамдуудтай холбогдож, ажлыг шуурхайлах талаар удаа дараа мэдэгдсэн боловч өнөөдрийг хүртэл төслийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ аваагүй, тендер зарлаагүй, ажил удааширч байгаа тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-т заасны дагуу Улсын Их Хурлын бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Танд хандан тавьж байна. Үүнд:


1. Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын явц болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг 2021 оны хэддүгээр сард эхлүүлж, хэдэн сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа талаар тодорхой хариултыг ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасны дагуу ирүүлж, 3.4-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.БАЯРСАЙХАН



2020000100